

БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТЫН МАЯГТ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31 ¹			
Баримт бичгийн нэр төрөл: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/27 дугаар тогтоол											Хаанаас, хэнээс буюу хаана хэнд: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол																						
Баримт бичгийг хүлээж авсан он, сар, өдөр, бүртгэлийн дугаар: 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр											Баримт бичгийн он, сар, өдөр, дугаар: 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр, дугаар: 25/27																						
Баримт бичгийн гарчиг (товч утга): Барилга, байгууламж балансаас баланст шилжүүлэх тухай. “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн баланст бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлалтай, нийт 10,278 м2 талбай бүхий “Нийслэлийн соёлын төв өргөө А,Б корпус” нэрээр нэрлэгдсэн барилга байгууламж болон нийслэлийн Өмчийн харилцааны газрын баланст бүртгэлтэй, нийт 3830 м2 талбай бүхий “Нийслэлийн соёлын төв өргөө Г корпус” нэрээр нэрлэгдсэн барилга, байгууламжийг “Нийслэлийн Соёлын төв өргөө” ОНӨААТҮГ-ын баланст тус тус шилжүүлсүгэй.																																	
Удирдлагын заалт (Хэнд шилжүүлсэн):																						 <p>НӨХТ газарт бүртгүүлж, хяналт тавих III/13.</p>											
Баримт бичгийг шийдвэрлэх хугацаа:																																	
Баримт бичгийн шийдвэрлэлтийн явц ²																																	
Баримт бичгийг шийдвэрлэсэн тухай тэмдэглэл ³																																	
Хэргийн индекс, дугаар (Хариу явуулсан бичгийн дугаар)																																	

Тайлбар:

¹ Дээд талын мөр баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавихад ашиглагдана. Баримт бичиг хянан шийдвэрлэх хугацааг энд дугуйлж тэмдэглэнэ.

² “Баримт бичгийн шийдвэрлэлтийн явц” Энэ хэсэгт баримт бичгийн хянан шийдвэрлэх үйл явцын мэдээллүүдийг тэмдэглэнэ.

³ Хэзээ, хэрхэн шийдвэрлэсэн тухай холбогдох мэдээллийг оруулна.



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 25/27

Улаанбаатар хот

Барилга, байгууламж балансаас
баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн баланст бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлалтай, нийт 10,278 м2 талбай бүхий “Нийслэлийн соёлын төв өргөө А, Б корпус” нэрээр нэрлэгдсэн, хавсралтад дурдсан нийт 8,175,430,745 (найман тэрбум нэг зуун далан таван сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун дөчин тав) төгрөгийн үнэлгээтэй барилга байгууламж болон нийслэлийн Өмчийн харилцааны газрын баланст бүртгэлтэй, нийт 3830 м2 талбай бүхий “Нийслэлийн соёлын төв өргөө Г корпус” нэрээр нэрлэгдсэн, хавсралтад дурдсан нийт 9,548,536,450 (есөн тэрбум таван зуун дөчин найман сая таван зуун гучин зургаан мянга дөрвөн зуун тавь) төгрөгийн үнэлгээтэй барилга байгууламжийг “Нийслэлийн Соёлын төв өргөө” ОНӨААТҮГ-ын баланст тус тус шилжүүлсүгэй.

2. Барилга, байгууламжийг шилжүүлэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

4. Тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан жагсаалтын 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.БАЯР

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/27
дугаар тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСТ ШИЛЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Баршил	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нийт үнэ	Хуримлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Нийслэлийн соёлын төв өрөө	
									Шилжүүлэн авах	
1	Соёлын төв өргөөний А,Б корпус барилга	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо	1987	м2	10,278	7,927,119,773.50	1,159,643,813.25	6,767,475,960.25		
2	СТӨ А, Б корпусын Асфальтан талбай		1987	м2	6590	9,885,015.00	7,908,012.64	1,977,002.36		
3	СТӨ А, Б корпус Зүлэгжүүлсэн талбай		1987	м2	3579	2,326,356.50	1,861,085.30	465,271.20		
4	СТӨ А, Б корпус газар		2022.11.07	м2	4670	151,214,600.00		151,214,600.00		
5	СТӨ А, Б корпус шугам ф200 дулаан		2022.11.07	ш	10	4,350,000.00	2,301,875.00	2,048,125.00		
6	СТӨ А, Б корпус шугам ф300 цэвэр усны шугам		2002.01.01	м	560	3,185,000.00	1,685,395.96	1,499,604.04		
7	СТӨ А, Б корпус ф100		2002.01.01	м	560	77,350,000.00	40,931,041.57	36,418,958.43		
8	СТӨ Г корпус		1987	м2	3830	9,548,536,450.00	1,609,576,604.72	7,938,959,845.28		
	НИЙТ ҮНЭ					17,723,967,195.00	2,823,907,828.44	14,900,059,366.56		